



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/17/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дүгээр сарын 17</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargal.6992@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5.1 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.24 № 2/46

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

005020320

Г 426 БАЯНХОНГОР ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨТҮГ-ЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Т.ОТГОНБААТАР ТАНАА

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.6 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь нь 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>254,118,365.76</u>	<u>309,656,946.73</u>
33	АВЛАГА	9,980,000.00	9,980,000.00
335	Бусад авлага	9,980,000.00	9,980,000.00
3351	Байгууллагаас авах авлага	9,980,000.00	9,980,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	244,138,365.76	299,676,946.73
351	Түүхий эд материал	9,804,272.73	17,923,172.73
35110	Тусгай зориулалттай материал	9,804,272.73	17,923,172.73
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	1,076,000.00	26,244,768.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	9,250,000.00	18,250,000.00
354	Хангамжийн материал	224,008,093.03	237,259,006.00
35410	Бичиг хэргийн материал	895,100.00	1,195,100.00
35420	Аж ахуйн материал	87,222,773.03	72,958,410.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,238,220.00	13,447,496.00
35450	Барилгын засварын материал	1,600,000.00	1,600,000.00
35470	Бусад хангамжийн материал	123,052,000.00	148,058,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,543,103,912.32</u>	<u>17,924,838,306.04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,543,103,912.32	17,924,838,306.04
392	Биет хөрөнгө	6,846,803,912.32	10,228,538,306.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	548,228,618.13	548,228,618.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-479,440,827.64	-507,749,927.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	144,644,000.00	437,144,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,085,883.58	-81,362,366.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	314,405,085.00	443,555,085.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,794,497.56	-204,772,551.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,077,200.00	13,688,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,161,499.63	-12,402,169.56
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	800,000.00	800,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,508,808,711.19	16,655,288,077.59
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,979,676,993.59	-7,063,878,659.21
393	Биет бус хөрөнгө	7,696,300,000.00	7,696,300,000.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,696,300,000.00	7,696,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>14,797,222,278.08</u>	<u>18,234,495,252.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,064,100.00</u>	<u>253,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,064,100.00	253,000.00
413	Өглөг	5,064,100.00	253,000.00
4136	Бусад өглөг	5,064,100.00	253,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,064,100.00	253,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>14,792,158,178.08</u>	<u>18,234,242,252.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	14,792,158,178.08	18,234,242,252.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,913,153,052.00	9,913,153,052.00
51101	Өмч: - төрийн	9,913,153,052.00	9,913,153,052.00
512	Хуримтлагдсан үр дүн	4,877,119,812.49	8,319,203,887.18
51210	Өмнөх үеийн үр дүн	4,877,119,812.49	4,877,119,812.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,442,084,074.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,885,313.59	1,885,313.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>14,797,222,278.08</u>	<u>18,234,495,252.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,572,546,960.39	6,088,650,892.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	644,782,390.39	4,813,783,892.40
120	Нийтлэг татварын бус орлого	644,782,390.39	4,813,783,892.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,652,300.00	8,543,636.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,652,300.00	8,543,636.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	927,764,570.00	1,274,867,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,544,970.00	13,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,544,970.00	13,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	817,942,300.00	1,171,442,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	817,942,300.00	1,171,442,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	87,277,300.00	90,424,100.00
1330	Төсвийн захирагчдаас	87,277,300.00	90,424,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,182,663,562.99	2,646,566,817.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,182,663,562.99	2,646,566,817.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,140,490,798.99	2,440,854,896.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	503,211,539.60	630,096,729.00
210101	Үндсэн цалин	503,211,539.60	630,096,729.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,812,380.73	91,737,294.20
210201	Тэтгэврийн даатгал	42,557,611.66	91,737,294.20
210202	Тэтгэмжийн даатгал	33,254,769.07	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,280,707.43	126,623,260.00
210301	Гэрэл, цахилгаан	86,525,647.43	124,075,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,755,060.00	2,548,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,211,975.85	34,118,011.48
210401	Бичиг хэрэг	3,495,800.00	2,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,146,666.80	23,492,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,527,777.05	1,985,930.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	835,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,434,000.00	5,504,481.00
210408	Бараа материал акталсны зардал	20,907,732.00	00.00
2105	Нормативд зардал	3,640,000.00	3,910,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,640,000.00	3,910,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,317,824.19	60,761,574.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,975,500.00	5,482,080.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,733,500.00	9,108,500.00
210604	Урсгал засвар	40,608,824.19	46,170,994.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,366,620.00	31,932,264.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,422,620.00	30,895,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	304,000.00	294,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	140,000.00	242,664.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,340,649,751.19	1,636,042,377.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	201,190,426.00	441,057,405.03
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,139,459,325.19	1,194,984,972.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,172,764.00	31,345,307.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,136,300.00	18,923,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,506,309.00	16,673,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,629,991.00	2,250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	36,464.00	12,422,007.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,464.00	12,422,007.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-610,116,602.60	3,442,084,074.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	433,258.71	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	433,258.71	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-433,258.71	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-610,549,861.31	3,442,084,074.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	929,571,870.00	1,283,410,636.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,807,300.00	8,543,636.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,807,300.00	8,543,636.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,807,300.00	8,543,636.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,807,300.00	8,543,636.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	927,764,570.00	1,274,867,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,544,970.00	13,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,544,970.00	13,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	905,219,600.00	1,261,867,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	817,942,300.00	1,171,442,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	87,277,300.00	90,424,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	916,315,470.00	1,275,410,636.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	916,315,470.00	1,275,410,636.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	874,142,706.00	1,244,065,328.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,027,354.33	636,146,443.29
210101	Үндсэн цалин	488,207,391.33	596,312,611.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,775,400.00	33,008,569.56
210105	Гэрээт ажлын хөлс	3,044,563.00	6,825,262.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,113,600.00	85,434,579.91
210201	Тэтгэврийн даатгал	56,066,900.00	54,406,679.91

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	3,409,300.00	6,205,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,727,500.00	4,964,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	681,900.00	1,241,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,228,000.00	18,616,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,280,707.43	126,623,260.00
210301	Гэрэл, цахилгаан	86,525,647.43	124,075,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,755,060.00	2,548,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,934,777.05	37,233,011.48
210401	Бичиг хэрэг	3,300,000.00	2,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,344,000.00	23,492,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,527,777.05	1,985,930.48
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	835,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,063,000.00	8,619,481.00
2105	Нормативд зардал	6,140,000.00	9,998,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,140,000.00	9,998,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,424,297.19	38,885,420.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,566,700.00	5,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,914,000.00	3,914,000.00
210604	Урсгал засвар	24,943,597.19	29,371,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,921,970.00	14,956,264.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,977,970.00	13,909,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	271,000.00	278,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	173,000.00	268,564.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,300,000.00	294,788,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,300,000.00	294,788,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,172,764.00	31,345,307.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,136,300.00	18,923,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,813,100.00	16,673,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,323,200.00	2,250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	36,464.00	12,422,007.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,464.00	12,422,007.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,256,400.00	8,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,256,400.00	8,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,256,400.00	8,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,256,400.00	8,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,256,400.00	8,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,256,400.00	-8,000,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,509,725,906.80	7,728,464,272.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,216,853,052.00	1,885,313.59	5,509,725,906.80	7,728,464,272.39
C07	Тайлант үеийн үр дүн	7,696,300,000.00	00.00	22,120,669.37	7,718,420,669.37
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	4,877,119,812.49	14,792,158,178.08
D01	2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	4,877,119,812.49	14,792,158,178.08
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	4,877,119,812.49	14,792,158,178.08
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,442,084,074.69	3,442,084,074.69
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,913,153,052.00	1,885,313.59	8,319,203,887.18	18,234,242,252.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,266,867,000.00	1,258,213,628.68	8,653,371.32	99.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,266,867,000.00	1,258,213,628.68	8,653,371.32	99.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,247,870,500.00	1,239,290,328.68	8,580,171.32	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	637,747,700.00	636,146,443.29	1,601,256.71	99.7
210101	Үндсэн цалин	592,834,438.00	596,312,611.73	-3,478,173.73	100.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,088,000.00	33,008,569.56	5,079,430.44	86.7
210105	Гэрээт ажлын хөлс	6,825,262.00	6,825,262.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,175,300.00	85,434,579.91	740,720.09	99.1
210201	Тэтгэврийн даатгал	55,147,400.00	54,406,679.91	740,720.09	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,205,600.00	6,205,600.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,964,500.00	4,964,500.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,241,100.00	1,241,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	18,616,700.00	18,616,700.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,917,300.00	126,623,260.00	294,040.00	99.8
210301	Гэрэл, цахилгаан	124,075,100.00	124,075,100.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,842,200.00	2,548,160.00	294,040.00	89.7
2104	Хангамж, бараа материалын зардал	37,928,800.00	37,233,011.48	695,788.52	98.2
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	2,300,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	23,492,600.00	23,492,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,273,200.00	1,985,930.48	287,269.52	87.4

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	835,000.00	365,000.00	69.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,663,000.00	8,619,481.00	43,519.00	99.5
2105	Нормативд зардал	10,000,000.00	9,998,000.00	2,000.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,000,000.00	9,998,000.00	2,000.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,914,000.00	40,885,420.00	28,580.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,914,000.00	3,914,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	31,400,000.00	31,371,420.00	28,580.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	00.00	500,000.00	0.0
210702	Дотоод албан томилолт	500,000.00	00.00	500,000.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,582,400.00	2,181,264.00	401,136.00	84.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,490,000.00	1,134,400.00	355,600.00	76.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	278,300.00	278,300.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	304,500.00	268,564.00	35,936.00	88.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	159,600.00	150,000.00	9,600.00	94.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305105000.00	300788350.00	4,316,650.00	98.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	305,105,000.00	300,788,350.00	4,316,650.00	98.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,996,500.00	18,923,300.00	73,200.00	99.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,996,500.00	18,923,300.00	73,200.00	99.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,673,300.00	16,673,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,323,200.00	2,250,000.00	73,200.00	96.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,266,867,000.00	1,258,213,628.68	8,653,371.32	99.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,261,867,000.00	1,249,669,992.68	12,197,007.32	99.0
132001	Орон нутгийн төсвөөс	1,171,442,900.00	1,159,245,892.68	12,197,007.32	99.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	8,543,636.00	-3,543,636.00	170.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	8,543,636.00	-3,543,636.00	170.9
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	80.00	80.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	56.00	56.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	11.00	11.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,544,970.00	12,775,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,544,970.00	12,775,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,544,970.00	12,775,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,544,970.00	12,775,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,544,970.00	12,775,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,544,970.00	13,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,544,970.00	13,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,544,970.00	13,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь “Ногоон байгуулламжийг нэмэгүүлэх, арчилж хамгаалах, моод үржүүлэг ойжуулалт, ойн зурвасын харуул хамгаалалт, хотын доторх нийтийн эзэмшлийн хөшөө, түүх соёлын дурсгалт зүйл, парк цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалт хамгаалалт усан ориглуур, усан толио зэрэг нийтийн эзэмшлийн усан байгууламжийн ашиглалт, явган хүний замын хавтан үйлдвэрлэл, гэрлэн дохионы засвар үйлчилгээ, арчлалт хамгаалалт, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хангаж ажлах чиг үүрэгтэй байна.

Тус байгууллагын бүтэц орон тоог захирлын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 тоот тушаалаар 1 хэлтэс 3 алба 80 ажилтан албан хаагчтай үйл ажиллагааг явуулахаар баталсан байна. Гүйцэтгэлээр үндсэн 69, гэрээт 11 ажилтантай үйл ажиллагааг явуулж аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10/36 тоот тогтоолоор ОНӨТҮГ болж статус нь өөрчлөгдсөн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь дотоод аудит хэрэгжүүлдэг бөгөөд тус байгууллагын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод төсвийн шинэчлэлтэй холбоотой хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэхгүй мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлээр бүртгэлд тусган тайлагнасан байна.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 18,238,495.2 мянган төгрөг болж өмнөх оноос 3,437,273.0 мянган төгрөгөөр буюу 17.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0.00	0.00
Авлага	9,980.00	9,980.00	0.00
Бараа материал	244138.3	299,676.90	55,538.60
Үндсэн хөрөнгө	21,228,033.60	25,795,773.90	4,567,740.30
Хуримтлагдсан элэгдэл	-6,684,929.70	-7,870,935.60	-1,186,005.90
Нийт хөрөнгө	14,797,222.20	18,238,495.20	3,441,273.00
Өр төлбөр	5064.1	253.00	-4,811.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,913,153.10	9,913,153.10	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,797,222.20	18,234,495.20	3,437,273.00

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 299,676.9 мянган төгрөг болж өмнөх оноос 55,538.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 290,505.8 мянга төгрөгийн бараа материал худалдан авсан, аймгийн ОНХС-

ын хөрөнгөөр 35,610.0 мянган төгрөгийн цемент, 48,093.1 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн материал, 2,470.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, өмнөх оны аудитын зөвлөмжөөр 65,936.5 мянган төгрөгийн ойн зурвасын усалгааны системийн материалыг тус тус данс бүртгэл үнэ төлбөргүй орлогоор авсан, 387,077.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой бөгөөд захирлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/20 тоот тушаалаар 7,007.5 мянган төгрөгийн бараа материалыг акталсан байна.

Бараа материал дансанд тусгай зориулалтын материал 8,118.9 мянга, дуусаагүй үйлдвэрлэл 25,168.7 мянга, бэлэн бүтээгдэхүүн 9,000.0 мянга, бусад хангамжийн материал 25,006.0 мянга төгрөгөөр тус тус өссөн голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 25,795,773.9 мянган төгрөг болж өмнөх оноос 4,567,740.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аймгийн ОНХС-ын хөрөнгөөр худалдан авсан 292,500.0 мянган төгрөгийн сонсомол автомашин 1, авто кран 1, ковш 1, жижиг оврын трактор 1 ширхгийг тээврийн хэрэгслийн дансанд, 125,000.0 мянган төгрөгийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, Аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10/44 тоот тогтоолоор 3,834,953.0 мянган төгрөгийн 2,7,9-р багийн автозам, 94,000.0 мянган төгрөгийн гүний худаг, 215,989.4 мянган төгрөгийн Гурван бүс цэцэрлэгт хүрээлэнгийн урсгал засвар, 5,720.0 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн хогийн савыг бусад үндсэн хөрөнгийн данс бүртгэлд орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данснаас аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны 10/46 тоот тогтоолоор машин тоног төхөөрөмжөөс 3,850.0 мянга, тавилга эд хогшлоос 389.0 мянга, бусад үндсэн хөрөнгөөс 4,740.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй бөгөөд 9,980.0 мянган төгрөг нь ажилчдын орон сууцны зураг, төсвийн үнийг 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагаар тусгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,364,185.0 мянга төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 421,312.3 мянган төгрөгөөр бууруулж 942,872.7 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,266,867.0 мянган төгрөг болгож 323,994.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн цахилгааны төлбөр нэмэгдсэн, үндсэн цалинг төсөв батлахдаа дутуу баталсантай холбоотой дутагдсан цалин, явган замын хавтан суурилуулах ажлын хөлсийг төсөвт нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71502 хөтөлбөрийн 80101, 80802, 81701, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,266,867.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 90,424.1 мянган төгрөгийг ОХНС-аас 1,171,442.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, туслах үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,171,442.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 90,424.1 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлогоос 8,543.6 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 1,159,245.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 90,424.1 мянган төгрөгийг зарцуулж 12,422.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн болно.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,258,213.6 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь цалин хөлсийг 1,601.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,316.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Код	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,166,070.50	1,157,858.33	8,212.17	99.3
2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал	18,996.50	18,923.30	73.20	99.6
3	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн хамгаалах зардал	81,800.00	81,432.00	368.00	99.6
Нийт			1,266,867.00	1,258,213.63	8,653.37	99.3

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030051425 дансаар Засаг даргын нөөц хөрөнгөөс давсны үнэ 3,000.0 мянга, туслах үйл ажиллагааны давсан орлого 10,000.0 мянган төгрөг тус тус төвлөрснөөс холбогдох

зардалд зарцуулан үлдэгдэл 225.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд шилжүүлсэн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого		/мян.төгрөгөөр/
д/д	Орлогын төрөл	Авсан санхүүжилт
1	Давсан орлого	10,000.00
2	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс давсны үнэ	3,000.00
Нийт орлогын дүн		13,000.00
1	Бор шороо	6,000.00
2	Материалын үнэ	3,775.00
3	Төвлөрүүлэх шилжүүлэг	225.00
4	Давс	3,000.00
Нийт зарлагын дүн		13,000.00

Эх сурвалж Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Амаржаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ-ын захирал Т.Отгонбаатар, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Болормаа нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,472,200.2 мянган төгрөгөөс 37,083.0 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 25,958.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл

Д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлбэл зохих/ удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлэл байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	0	0	3
2	Хагас жил	4	4	4	0	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0	
4	Сар бүр	3	36	36	0		
5	Тухай бүр	8	96	93	3	0	
	Нийт	27	151	145	3	0	3

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн систем

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн системд нийт мэдээлбэл зохих 151 мэдээллээс бонд, зээл өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс төсөв өмч, хөрөнгө мөнгө зарцуулах өр авлага, үүсгэсэн аливаа шийдвэр тухай бүр мэдээлэх 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 250,117.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 213,494.5 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 36,623.3 мянган төгрөгийн 5 зөрчилд алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 66 тоот албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	100
Албан шаардлага	3	213,494.5	3	213,494.5	100
Зөвлөмж	5	36,623.3	5	36,623.3	100
Нийт дүн	8	250,117.8	8	250,117.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант хугацаанд Баянхонгор сумын Засаг даргатай 211,950.0 мянган төгрөгийн аймгийн төв доторх явган хүний зам тавин ажлын хөлс олгох гэрээний дагуу 11 харилцагчид 180,000.0 мянган төгрөгийг олгож ХХОАТ-т 31,950.0 мянган төгрөгийг суутган шилжүүлсэн байна. Энэ нь Баянхонгор сум дээр худалдан авах ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй байсан бөгөөд аудитын хугацаанд нотлох үзэх боломжгүй байсан тул дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,285.5 мянган төгрөгийн зөрчилд¹ алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлэв.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Өгсөн зөвлөмж:

1. Ажил олгогч болон даатгуулагчийн НДШ-ын хооронд нь гүйлгэн зарцуулж 10,303.5 сая төгрөгийг шууд зардалд бичилт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч дүнг Эд хөрөнгийн тооллогын дүнг нягтлан бодогч тооцоо бодсон акт байхгүй мөн тооллогын дүнг захирлын тушаалаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 73 дугаар зүйлийн 73.2 дахь заалтыг мөрдөж, бараа материалын устгалын актыг тухай бүр үйлдэж, анхан шатны баримтад хавсаргаж байх гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид тооллогын акт материалыг үндэслэн нягтлан бодох бүртгэлд тусгаж тооцоог бодон дансны үлдэгдлийг шалгаж, дүнг баталгаажуулан ажиллах зөвлөмж өгөв.

3. Тус байгууллага нь 2020 онд ажилчдын орон сууц барих зорилгоор 9,980.0 мянган төгрөгийн зураг төсвийг төсвийн хөрөнгөөр хийлгүүлсэн ба барилга барих газар 2022 оны 02 сарын 09-ний өдрийн А/59 тоот аймгийн засаг даргын Захирамжаар эзэмших эрх нь цуцлагдсан байна. Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж найдваргүй авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах, цаашид аливаа авлага үүгэхээс өмнө хянаж баталгаажуулан тооцоо нийлж үүсгэж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажил олгогч болон даатгуулагчийн НДШ-ын хооронд нь гүйлгэн зарцуулж 10,303.5 сая төгрөгийг шууд зардалд бичил хийсэн байна.	1	10,305.5	0	0	0	0	1	10,305.5	0	0	0	0
2	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч дүнг Эд хөрөнгийн тооллогын дүнг нягтлан бодогч тооцоо бодсон акт байхгүй мөн тооллогын дүнг захирлын тушаалаар баталгаажуулаагүй байна.	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0
3	Тус байгууллага нь 2020 онд ажилчдын орон сууц барих зорилгоор 9,980.0 мянган төгрөгийн зураг төсвийг төсвийн хөрөнгөөр хийлгүүлсэн ба барилга барих газар 2022 оны 02 сарын 09-ний өдрийн А/59 тоот аймгийн засаг даргын Захирамжаар эзэмших эрх нь цуцлагдсан байна. Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж найдваргүй авлага үүсгэсэн байна.	1	9,980.0	0	0	0	0	1	9,980.0	0	0	0	0
Нийт дүн		3	20,285.5	0	0	0	0	3	20,285.5	0	0	0	0

оОо